



**BASALTWOOL®**  
МОНГОЛ БАЗАЛТ ХК



**SUSTAINABLE  
DEVELOPMENT GOALS**  
17 GOALS TO TRANSFORM OUR WORLD

# Тогтвортой Хөгжлийн тайлан

# Гарчиг

Ерөнхий агуулга	03
Захиралын мэндчилгээ	04
Бидний тухай	05
Бүтээгдэхүүн	07
Бидний үнэ цэнэ, үнэлэмж	08
Тогтвортой хөгжлийн зорилтууд	09 – 25

# Уур амьсгалд тэсвэртэй ирээдүйг бий болгох нь...

Монгол орон нь уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн эмзэг, өртөмтгий орнуудын нэг бөгөөд сүүлийн 70 жилд агаарын дундаж температур 2.1C-аар нэмэгдсэн байна. Мөн уур амьсгалын өөрчлөлт байгалийн экосистем төдийгүй хөдөө аж ахуй, мал аж ахуй, газар тариалан зэрэг нийгэм, эдийн засгийн гол салбаруудад сөргөөр нөлөөлж байгаа нь цаг алдалгүй, яаралтай арга хэмжээ авах хэрэгцээтэй байгааг илтгэж байна[1].

Сүүлийн 28 жилд (1992-2020) хүлэмжийн хийн бүрэлдэхүүнд багтдаг нүүрсхүчлийн хийн агууламж 16.5 хувиар, метаны агууламж 8.8 хувиар тус тус нэмэгджээ[2].

Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар нь харилцан уялдаатай бөгөөд байгаль орчин, эдийн засаг, нийгэм, технологийн эрсдэлийг дагуулдаг. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнд дасан зохицох, багасгах, бизнес, байгаль орчин, олон нийтийн уур амьсгалд тэсвэртэй байдлыг дэмжих зайлшгүй шаардлагатай байна.

Монгол Базальт ХК нь галт уулын чулуулгийг чулуун хөвөн болгон хувиргаж, нийгэмд тулгарч буй уур амьсгалын өөрчлөлтийн томоохон сорилтуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэж, орчин үеийн амьдралыг баяжуулж, аюулгүй, эрүүл, уур амьсгалд илүү тэсвэртэй нийгмийг бий болгох шинэ боломжийг бий болгодог.

Чулуун хөвөн нь галд тэсвэртэй, дуу чимээ тусгаарладаг, эдэлгээ урт, эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй гэх мэт олон давуу талтай байгалийн гаралтай материал бөгөөд үүнийг барилга байгууламж, үйлдвэр, тээвэр, цэцэрлэгжүүлэлт, усны менежментэд ашиглахад тохиромжтой.



1.Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох болон эрсдлийн менежментийг сайжруулах төсөл [https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/presscenter/pressreleases/2021/\\_-\\_-\\_-\\_-\\_-\\_-\\_-\\_-\\_-\\_-\\_-\\_-\\_-\\_-\\_-\\_.html](https://www.mn.undp.org/content/mongolia/en/home/presscenter/pressreleases/2021/_-_-_-_-_-_-_-_-_-_-_-_-_-_-_-_.html)  
2.Уур амьсгалын өөрчлөлт Монголд хэрхэн нөлөөлж байна вэ? <https://ub.life/p/27688>



ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
А.ЭНХГЭРЭЛ

## Тогтвортой ирээдүйн төлөө Тэсвэртэй хотыг бүтээлцэнэ.

Монгол Базальт Компанийн 2022 оны Тогтвортой хөгжлийн тайлантай танилцана уу.

Тогтвортой хөгжил нь манай улсын хувьд алс холын мөрөөдөл байсан цаг саяхан. Өнөөдөр, тогтвортой бизнес нь зөвхөн ашиг орлогод бус хүний амьдрах орчин, нийгмийг сайжруулдаг суурьтай байх шаардлага бий болсон байна.

Уур амьсгалын өөрчлөлт гэх нийгэмд тулгарч буй томоохон хүндрэлүүдийн үр дүнтэй шийдлийг бүтээдэг компани удирдан явж байгаа миний хувьд нэр төрийн хэрэг. Бидний бүтээгдэхүүний байгаль орчин, нийгэмд үзүүлэх эерэг нөлөө насан туршийн хугацаанд байдаг нь сэтгэл дүүргэм.

Сүүлийн 5 жилийн хугацаанд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн ашиглалтынхаа хугацаанд өөрийг нь бүтээхэд зарцуулсан нүүрс хүчлийн хийгээс 100 дахин их нүүрс хүчил хэмнэх өвөрмөц онцлогтой бөгөөд насан туршийнхаа хугацаанд хэмнэх эрчим хүчний хэрэглээг тооцоход дахин шинээр цахилгаан станц барих хэмжээний хэмнэлтийг бий болгосон байдаг. Ийм ч учраас манай компанийн Философийн цөм – Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалууд нягт уялдаатай юм.

Монгол Базальт ХК-нь 2014 онд гэр хорооллын айлуудын дахин дулаалгын аянууд санаачлан зохион байгуулснаас эхлүүлээд, 2018 онд олон нийтэд танилцуулсан үйл ажиллагааны тайландаа Тогтвортой хөгжлийн бүлэг нэмж оруулан, цаашид олон төсөл хөтөлбөрүүд, арга хэмжээ, дотоод/гадаадын илтгэл танилцуулга бүрийнхээ төвд нь SDG-ийн үзэл баримтлалуудыг гол зорилгоо болгон шингээж ирсэн нь бидний үнэн эрмэлзлийг харуулна.

Дэлхий даяар хэрэглэгдэж байгаа эрчим хүчний 40 гаруй хувийг барилгын дулаан болон хөргөлтөд хэрэглэдэг бөгөөд хуучин барилгуудыг дахин дулаалах нь, шинэ барилга барихаас нөөцийн хувьд хамгийн хямд, оновчтой хуваарилалт болдог ба барилгын материалын нүүрс хүчлийн хийн ул мөрийг 70%-иар бууруулах боломжийг олгодог.

Эдгээр үзүүлэлтүүд нь бидний давуу тал биш, харин бусдаас онцлог, суурь шинж чанар билээ.

# Бидний тухай

Монгол Базальт компани нь Монгол улсын хамгийн анхны базальт чулууг 2000С градуст хайлуулах технологийг нутагшуулан эзэмшиж чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын үйлдвэр байгуулсан.

Өнгөрсөн 15 жилийн турш бид өөрсдийн know-how болон мятаршгүй хөгжих хүсэл эрмэлзлээ, хийсэн бүхэндээ шингээн иржээ. Бидний үүсгэн байгуулагч нар болон хамт олон хуучин арга техникийг тогтмол сорин, шинэлэг санааг туршин хөгжүүлдгийн үр дүнд бид өнөөдөр байгалийн ганц чулуунаас олон төрлийн дэвшилтэд шийдлүүдийг гарган авч байна.

Инноваци шингэсэн үйлдвэрлэл технологиороо салбартаа манлайлан хөгжүүлж, хүний амьдрах орчинг эрүүл тав тухтай, байгаль дэлхийд ээлтэй, барилга хийцийн эрсдэлгүй, ирээдүйг хойчдоо өвлүүлэн үлдээх, ямагт өсөх үнэ цэнэ бүхий баталгаат хөрөнгө оруулалтыг бий болгохоор зорин ажиллаж байна.

## КОМПАНИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ:



2009 оноос чулуун хөвөн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж эхэлсэн, 2013 онд СТУ шугам хоолойн дулаалгын технологийг нэвтрүүлэн дулааны шугам хоолойн дулаалга, шинэчлэл, тохируулгын ажлуудыг хийж эхэлсэн.

2021 оноос GROWOOL босоо хүлэмжийн хөрсгүй тариалалтын технологи нэвтрүүлсэн. Босоо хүлэмжийн технологи нь тариалалтын талбайн хэмжээг 76%, усны хэрэглээг 80-90% хүртэл багасгана.

2021 онд Базальт Файбер арматур, Базальт кассетан сэндвич хавтангийн үйлдвэрлэлийн технологи нэвтрүүлж, 2022 оны 2 дугаар улиралд үйлдвэрээ ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

# Бүтээгдэхүүн

Эрдэст чулуун хөвөн дулаан тусгаарлагч материал нь байгаль орчин, хүн нийгэмд ээлтэй, нүүрс хүчлийн хий, түүний ул мөрийг бууруулах, эрчим хүч, дулааны хэмнэлттэй, чанарын эрсдэлгүй, галын аюулгүй байдлыг олгосон үндэсний тогтвортой бүтээн байгуулалтуудыг дэлхийн чанар үзүүлэлтэд нийцүүлэх стратегийн онц чухал бүтээгдэхүүн билээ.

- Basalt fiber, төмөр утсаар оёсон чулуун хөвөн хуйлмал хөнжил (Гадуураа фольга, төмөр тор, шилэн даавуу г.м) ДУЛААЛГЫН шинэ бүтээгдэхүүн. Агааржуулалтын хоолой, Эрчим хүч, дулааны шугам сүлжээ, Нефтийн байгууламж г.м-Ажлыг улам амар болгоно.

- "БАЗАЛТ АРМАТУР" бүтээгдэхүүн нь бетонон зам, гүүр болон Барилгын тэгээс доош байгууламж, бетон хийц эдлэл кольцо, лотки зэрэгт хэрэглэх нь хийцийг хөнгөн бат бэх болгохоос гадна зэврэлтээс хамгаалж насжилтыг уртасгана.

- Архитектурын уян хатан төгс шийдэл, оффис, супермаркет, гараж, спортын ордон, үйлдвэрийн барилгын хийц технологид инновацийн шинэчлэл төгс шийдэл боллоо. Хөдөлмөрийн бүтээмж 3 дахин нэмэгдүүлж, барилга угсралтын хугацааг 2 дахин багасгана.

- Базальт чулуунаас гарган авсан чулуун хөвөн хөрсийг хүлэмжид хөрс орлуулагч болгон ашигладаг. Түүний онцлог бүтэц нь ургамлын үндсийг чөлөөтэй ургах нөхцөлийг бүрдүүлж, тэжээлийн уусмалын найрлагыг өөрчилдөггүй давуу талтай.



# Бидний НОГООН үнэлэмжээс




Нийслэлийн бүтээн байгуулалтын  
дээд шагнал GARUDA  
2018



"Байгальд ээлтэй дэвшилтэт  
технологи нэвтрүүлсэн байгууллага"  
Ногоон гэрчилгээ  
2019




Шинэ хороо агаар орчны бохирдлыг  
бууруулах, дахин дулаалгын төсөл  
2021



Агаар орчны бохирдолтой тэмцэх  
Өнтэй өвөлжье үзэсгэлэн  
2021



Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ  
үзүүлэх мэргэжлийн байгууллага /  
ЭСКО/-ын магадлан итгэмжлэл  
2022



Цагийн хүрдний баатрууд  
2022



---

## Тогтвортой хөгжлийн зорилтууд

Тогтвортой байдал нь шинэлэг бүтээгдэхүүн, шийдэл, түншлэлээр дамжуулан тогтвортой хөгжлийн сорилтуудыг бизнесийн боломж болгон хувиргахад чиглэдэг бидний бизнесийн стратегийн салшгүй хэсэг юм.

Монгол Базальт ХК-ийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн нь нийгэм, эдийн засаг, байгаль орчны олон тал дээр эерэг үнэ цэнийг бий болгодог.



# Тогтвортой хөгжлийн зорилтууд

Тогтвортой хөгжлийн тайлан |  
2021

Уур амьсгалын өөрчлөлтийн Монголд үзүүлж буй нөлөө:



Цаг агаарын эрс тэс уур амьсгал, хэт халалтаас шалтгаалан газрын доройтол, цөлжилт нэмэгджээ. Тодруулбал, Монгол орны газар нутгийн хэмжээ 76,8 хувь нь дунд болон хүчтэй цөлжилтөд өртжээ[1].



Манай орны агаарын дундаж температур сүүлийн 80 гаруй жилд 2.25 хэмээр буюу дэлхийн дунджаас даруй 2.5 дахин нэмэгдэж, хур тунадасны хэмжээ жил бүр 8 хувиар багассан байна[1].



Аадар бороо, хүчтэй салхи, их цас, үер, ой хээрийн түймэр гэх мэт гамшигт үзэгдэл сүүлийн 20 жилд 2 дахин нэмэгдсэн[1].



Сүүлийн 28 жилд (1992–2020) хүлэмжийн хийн бүрэлдэхүүнд багтдаг нүүрсхүчлийн хийн агууламж 16.5 хувиар, метаны агууламж 8.8 хувиар тус тус нэмэгджээ[1].



**SDG 17:**  
 Үр дүнтэй хамтын ажиллагаанд оролцох.

**SDG 13:**  
 Нүүрс хүчлийн хий бага ялгаруулах барилга байгууламж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.



ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭ

ТҮҮХИЙ ЭД

**SDG 12:**  
 Хог хаягдалгүй үр ашгтай үйлвэрлэл.



**SDG 7:**  
 Үйлдвэрийн болон оффисын барилгын фасад засвар шинэчлэл хийж эрчим хүчний хэмнэлтэй болсон.

**SDG 6:**  
 Ашигласан усны нөөцийн сан байгуулж усны дахин хэрэглээг нэвтрүүлж үйлдвэрт сарвал усыг хэрэглээнд оруулсан.



**SDG 13:**  
 Үйлдвэрийн гарах хоолойн уудны филтер системийг дахин сайжруулж нүүрс хүчлийн хийн ялгаралтыг стандартаас бага хэмжээнд хүргэсэн.

**SDG 8:**  
 Акумулгүй ажиллагааг сайжруулж, сул зогсолтыг бууруулсан.

**SDG 9:**  
 Бат бөх, галц тэсвэртэй барилга байгууламжийг нэмэгдүүлэх.

**SDG 8:**  
 Тогтвортой ажлын байр, эдийн засгийн өсөлтийг дэмжих.



**SDG 3:**  
 Дуу чимээний тусгаарлалттай барилга байгууламжийг нэмэгдүүлэх.




**SDG 13:**  
 Нүүрсгэрэгчийн хэмнэлтэй барилга байгууламж, үйлдвэрлэлийг идэвхжүүлэх.

**SDG 11:**  
 Оролгод нийцсэн орон сууц, эрчим хүчний хэмнэлтийг дэмжих.

**SDG 7:**  
 Эрчим хүчний хэмнэлтэй барилга үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх.

**SDG 6:**  
 Тарилалтын усны хэрэглээг багасгах.

**SDG 2:**  
 Тогтвортой хүнсний үйлдвэрлэлийг бий болгох.



Тогтвортой хөгжлийн зорилт.

Бүтээгдэхүүний хэмжүүр.

# Тогтвортой хөгжлийн зорилтууд

Дэлхий нийтийн тулгамдсан асуудал болох экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, хүлэмжийн хийг бууруулах, агаарын бохирдлыг багасгах, эрүүл, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд бодит дэмжлэг үзүүлж чадахуйц нийгэм, олон нийтийн хүртэх өгөөж өндөртэй салбарт компани үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд Монгол Базальт ХК-ийн философи тогтвортой хөгжлийн зорилтуудтай нягт улдаа холбоотой.

Бид тогтвортой хөгжлийн 17 зорилтоос 10-ыг нь эрэмбэлэн манай бизнест хамгийн их ач холбогдолтой, ахиц дэвшил, ололт амжилтыг хэмжих шалгуур болгон ашиглаж байна.

Бид бүтээгдэхүүнээ ашигласнаар тогтвортой хөгжилд хамгийн их эерэг нөлөө үзүүлдэг. Бидний бүтээж буй бүтээгдэхүүн нь иргэдийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг сайжруулаад зогсохгүй уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх шийдэлүүдийн нэг юм.





## Дулаалгын материал нийлүүлсэн төсөл: Хадат вилла

Тогтвортой хөгжлийн тайлан | 2021



**SDG-2**

Илүү үр ашигтай хүнсний үйлдвэрлэлийг бий болгох /GROWOOL/



**SDG-3**

Дуу чимээг бууруулж, дуу чимээний тусгаарлалтай барилга байгууламжийг бий болгох /SOUND INSULATION/



**SDG-6**

Газар тариалангийн болон ногоон байгууламжийн усны үр ашгийг нэмэгдүүлэх /GROWOOL/



**SDG-7**

Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх



**SDG-8**

Тогтвортой ажлын байр, эдийн засгийн өсөлтийг дэмжих



**SDG-9**

Бат бөх, галд тэсвэртэй дэд бүтцийг бий болгох



**SDG-11**

Хуучин угсармал болон амьны орон сууц дахин дулаалах



**SDG-12**

Ухаалаг хэрэглээ ба зарцуулалт



**SDG-13**

Нүүрсхүчлийн хий бага ялгаруулах барилга байгууламж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх



**SDG-17**

Үр дүнтэй хамтын ажиллагаанд оролцох

2 ZERO HUNGER



## Priority Goal and Targets #1: Тогтвортой хүнсний үйлдвэрлэл




Чулуун хөвөн ашиглан гидропоник технологиор тариалалт хийх нь байгаль цаг уураас хараат бус жилийн дөрвөн улирал тогтвортой ургац хураах боломжыг бүрдүүлэх болно.


Монгол Базальт ХК нь 2019 оноос GROWOOL /ургамал тарих чулуун хөвөн/ старт алыг бойжуулан хадгалалт тээвэрлэлтээс үүсэх хүнсний ногооны хаягдалыг багасгах, усны хэрэглээ бага тариалалтын технологийг нэвтрүүлэх, хуурай сэрүүн уур амьсгалтай монгол орны нөхцөлд байгаль цаг уураас хараат бус жилийн турш тогтвортой тариалалт хийх боломжтой шинэ технологи болох гидропоник технологийн талаар сургалт зөвөлгөө, гарын авлага, мэдээлэлийг иргэд аж ахуй нэгж, нийгэмд түгээн ажиллаж байна.

Анхны монгол хэл дээрх хөрсгүй тариалалтын гидропоник технологийн зааварчилгаа, гарын авлага номыг бэлтгэн, 2021 оны 11 сард худалдаанд гаргасан.

### 3 GOOD HEALTH AND WELL-BEING



## Priority Goal and Targets #2: Дуу чимээг бууруулж, дуу чимээний тусгаарлалтай барилга байгууламжийг бий болгох



Дуу чимээтэй орчинд амьдардаг хүмүүст цусны даралт ихсэх, дутуу жинтэй хүүхэд төрүүлэх гэх мэт сөрөг үр дагавар тулгарч байна.

Чулуун хөвөн хавтан нь дуу чимээг өөртөө шингээн тусгаарлах шинж чанартай тул барилгын гаднаас дуу чимээ нэвтрүүлэхгүй бөгөөд барилгын доторх дуу чимээг ч гадагш гаргахгүй тусгаарлаж байдаг.

35-45дб дуу чимээнд тав тухтай байдаг ба чулуун хөвөн хавтангаар байшингаа дулаалсанаар дуу чимээг 49-84% хүртэл бууруулан тусгаарладаг байна. Авто машины дуут дохио 80дб бөгөөд дуу чимээний тусгаарлалттай хананы цаана 43дб болж сонсогдоно.

## 6 CLEAN WATER AND SANITATION



Нийтэд хүртээмжтэй, хүнсний ус болон ариун цэврийн тогтвортой хэрэглээний менежмент бий болгох

### Priority Goal and Targets #3: Газар тариалангын болон ногоон хүрээлэнгийн усны үр ашгийг нэмэгдүүлэх

Монгол улсын хүнсний ногооны 80%-г импортын бүтээгдэхүүн эзлэж байна. COVID-2019-н нөлөөгөөр монгол улсад өргөн хэрэглээний хүнсний ногооны үнэ нэмэгдэж хомсдол бий болж буй энэ цаг үед бид иргэн бүр хүнсний ногоогоо өөрөө ургуулах боломжтойг сурталчилан таниулж байна.

Монгол улсын цэвэр усны хэрэглээний 12%-г усалгаатай тариалан буюу газар тариаланд ашигладаг бөгөөд базальт чулуун хөвөн ашигласнаар газар тариаланд ашиглаж буй усыг 80-90% хүртэл хэмнэх бүрэн боломжтой юм.

Усны хэрэглээг 80%



**SDG-2**  
Enabling more efficient food production



**SDG-6**  
Enhancing water efficiency in horticulture



Талбайн  
хэмжээг

76%

бууруулна.



## Priority Goal and Targets #4: Эрчим хүчний хэмнэлттэй барилга байгууламж, үйлдвэрлэлийг идэвхжүүлэх

Барилгын салбар нь Монгол Улсын дулааны эрчим хүчний 56%, цахилгаан эрчим хүчний 38%-ийг хэрэглэж хүлэмжийн хийн ялгарлын (ХХЯ) ойролцоогоор 30%-ийг бүрдүүлдэг байна.

Улаанбаатар хотод 1990 оноос өмнө баригдсан, дулаалах шаардлагатай нийт 420 гаруй орон сууцны барилга байна.

Эдгээр барилгуудын халаалтад жилдээ 1.1 тэрбум кВт.ц эрчим хүч буюу 20 орчим тэрбум төгрөг зарцуулж, 1190 мянган тонн хүлэмжийн хий ялгаруулдаг. Эдгээр барилгуудыг дулаалснаар халаалтад зарцуулах хөрөнгийн хэмжээ 20-40 хувь буурах боломжтой[1].

2017-2021 оны хооронд хэрэгжсэн дахин дулаалгын төслүүдийн хүрээнд Монгол Базальт Компани 300 орчим айлд дахин дулаалга хийж өвлийн 2 сарын хугацаанд хэмжилт судалгаа хийхэд Нүүрс 65%, Үнс 65%, Утаа 65% дунджаар буурсан үзүүлэлттэй байна. Мөн бид өөрийн оффис барилга, үйлдвэрийн барилгыг дулаалж эрчим хүчний хэрэглээгээ 70%-80%-иар бууруулан ажиллаж байна.

2022 онд Эрчим хүчний зохицуулах хорооноос Эрчим хүчний үр ашгийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын магадлан итгэмжлэл олгосон.



## 8 DECENT WORK AND ECONOMIC GROWTH



### Priority Goal and Targets #5: Тогтвортой ажлын байр, эдийн засгийн өсөлтийг дэмжих



30%



70%

ЗОХИСТОЙ ХӨДӨЛМӨР нь зорилго төдийгүй ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ГОЛ ХӨДӨЛГҮҮР юм. Хүмүүс илүү олноороо зохистой хөдөлмөр эрхэлнэ гэдэг нь эдийн засаг илүү хурдацтай, хүртээмжтэй өснө гэсэн үг. Өсөлт ийнхүү сайжирснаар зохистой ажлын байр бий болгоход зарцуулагдах нөөц нэмэгдэнэ [1].

2019-2021 оны хооронд тогтвортой ажлын байрны өсөлт 20%-30% байгаа бөгөөд шинээр үйлдвэр ашиглалтанд оруулсанаар ажлын байрны тоо хэмжээ 2 дахин өсөх хандлагатай байна. Мөн Монгол Базальт ХК-ийн нийт ажилчдын 30% нь эмэгтэй бөгөөд 95% нь дээд боловсролтой чадварлаг ажиллах хүчин юм.

9 INDUSTRY, INNOVATION  
AND INFRASTRUCTURE



**BASALTWOOL®**

ГАЛД ШАТДАГГҮЙ ДУЛААН ТУСГААРЛАГЧ

Стандарт норм хангасан, галд шатдаггүй  
барилгын материалууд хэрэглэвэл хүний амь  
нас, эд хөрөнгийн хохирлоос сэргийлнэ.

ТОО БАРИМТААР

2200

объектийн гал түймэр  
жилд дунджаар  
Монгол улсад гардаг

55

хүний амь нас эрсэддэг

+30 тэрбум

төгрөгийн хохирол учруулдаг

## Priority Goal and Targets #6: Илүү бат бөх, галд тэсвэртэй дэд бүтцийг бий болгох

Ямар ч барилга галд автах эрсдэлтэй, гагцхүү түүнд цаг хожих гал дэмждэггүй материал ашиглах л чухал. Барилгын галын оргил температур эхний 5 минутын дотор 900+ градус хүрнэ, харин BASALTWOOL эрдэс чулуун хөвөн 2000+ градус температурт ч шатахгүй, барилгаа хамгаалдаг цорын ганц A1 зэрэглэлийн тусгаарлагч юм.

Бид NCD групп Ривер Гарден төсөл, Их Модун төсөл, Фужи костраکش Хан Уул төсөл, Жигүүр Гранд ROMANA RESIDENCE, хөшигтийн хөндийн нисэх онгоцны буудал, SKY RESIDENCE, Хадат Вилла 2, Гэрлуг вилла зэрэг барилгын төслүүд, мөн Улсын Их дэлгүүр, Шангри-Ла зэрэг барилгууд галд өртсөний дараагаар галын хамгаалалт болон дуу чимээ, дулаан тусгаарлагчаар базальт вүүл чулуун хөвөн хавтан бүтээгдэхүүнийг сэргээн засварлалтандаа ашигласан нь бидний хувьд галын аюулгүй дэд бүтэцийг бий болгох ажилд хувь нэмэрээ оруулсан явдал байлаа.

Мөн бид хамтран Дулааны цахилгаан станц 1, 2, 3-ийн шугам хоолойн дулаалга, шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэсэн.



## 11 SUSTAINABLE CITIES AND COMMUNITIES



# Priority Goal and Targets #7: Хуучин угсармал болон амьны орон сууц дахин дулаалах

Дулаалгын материал барилгын нийт өртөгийн 2–5 хувийг эзэлдэг.

Иргэдийн төлбөрийн чадварт нийцсэн орон сууцыг барих ажил 2022-2027 оны хооронд 6 жилийн хугацаанд 5 үе шаттайгаар хэрэгжинэ. Төслийн хүрээнд гэр хорооллын дахин төлөвлөлтөд нийцсэн хотын дэд бүтэц, нийтийн зориулалттай барилга байгууламжийг барих бөгөөд Нийслэлийн өмчлөлд байх Түрээсийн

орон сууц, нүүрстөрөгч бага ялгаруулдаг технологи бүхий "Орлогод нийцсэн орон сууц", "Зах зээлийн үнэлгээтэй орон сууц"-ыг барьж байгуулах ажлыг гүйцэтгэнэ[1].

Барилгын Материалын сонголт тухайн барилгын ХО-ын насжилт, ашиглалтын зардал хэрэглэгчид дээр хэрхэн дарамт, алдагдал болж ирэхийг шийддэг. Тухайн үедээ хямд материалаар шийдэл хийж зардалаа хэмнэх боловч ХЭРЭГЛЭГЧ анх худалдан авсан үнээсээ 3–5 дахин зардлыг амьдрах, ашиглах 20–30 жилийн хугацаанд гаргаж хохирдог. Анхнаасаа чанартай, удаан эдэлгээтэй, барилгын насжилтыг уртасгах барилгын материал ашигласанаар ирээдүйн зардалыг бууруулна.

12 RESPONSIBLE  
CONSUMPTION  
AND PRODUCTION



## Priority Goal and Targets #8: Ухаалаг хэрэглээ ба зарцуулалт

BASALTWOOL дулаан тусгаарлагчийг акустик дүүжин тааз, гудамж замын дуу чимээ тусгаарлагч барьер, барилгын гадна талын засал чимэглэлийн хавтан, тусгай зориулалтын техникийн мяндсан утас, төмөр замын доргио тусгаарлагч хавтан, хүнсний ногоо болон цэцэг ургуулах хиймэл хөрс болгон ашиглаж байна. Эдгээр бүх материалуудыг чулуун хөвөнгөөс гаргаж авдаг.

Мөн Базальт чулуун хөвөн нь эдэлгээ урттай бөгөөд барилгын насжилтыг уртасгадаг тул хэрэглэгчдийн насан туршийн хэрэглээ юм. Базальт чулуун хөвөн үйлдвэрлэхэд бүтээгдэхүүний хог хаягдал гардаггүй үр ашигтай, байгальд ээлтэй технологи юм.

Ашигласан усны нөөцийн сан байгуулж усны дахин хэрэглээг нэвтрүүлж үйлдвэрийг саарал усны хэрэглээнд оруулсан.



## Priority Goal and Targets #9: Нүүрсхүчлийн хий бага ялгаруулах барилга байгууламж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх

Сүүлийн 5 жилд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн



2,3

сая Мвт.ц эрчим хүч хэмнэнэ.



1

сая тонн ХХЯ багасгана.

Эрчим хүч хэмнэх Үндэсний хөтөлбөр хэрэгжсэнээр 610 орчим сая квт.ц цахилгаан эрчим хүч хэмнэх, ойролцоогоор 600 гаруй мянган тонн CO2 хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, хэрэглэгч талдаа 80 орчим тэрбум төгрөгийн эрчим хүчний зардлын бууралтыг тус тус бий болгох боломж бүрдэнэ гэдэг урьдчилсан тооцоо гарсан байдаг.

Барилгын дулааны алдагдалыг бууруулсанаар түүхий нүүрсний хэрэглээ, галлагааны давтамж буурах ба улмаар агаарын бохирдол, нүүрс хүчлийн хийн ялгарал болон үнс хогны хаягдал 70 хүртэлх хувиар буурсан үзүүлэлтийг Монгол Базальт компанийн хамтран ажилласан Дулаан аян, Шинэ хороо, Гэрэлтэй цонх зэрэг дахин дулаалгын төслүүдийн үр дүнгээс харах боломжтой.



## Priority Goal and Targets #10: Үр дүнтэй хамтын ажиллагаанд оролцох

Бид тогтвортой хөгжилд бусдыг манлайлж, уриалан хамт өсөж дэвшихийг эрмэлзэхийн хэрээр олон байгууллага, нэгдлүүдтэй хамтран ажиллахаас гадна идэвхитэй гишүүн байж, бусдаас суралцаж, өөрийн сайн туршлагаа хуваалцан тогтвортой хөгжил, компанийн нийгмийн хариуцлагыг зохистой, зөв чиглэлд хөгжүүлэхэд үлгэр жишээ ажиллахыг эрмэлзэж ирсэн.

Монгол Базальт ХК-ийн үйл ажиллагааны жилийн тайланг олон нийтэд нээлттэй, ил тод тайлагнахаас гадна зохицуулагч байгууллагууд, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид, хамтран ажиллагч байгууллагууд, олон улсын гэрээ, нэгдэлд тогтмол тайлангаа хүргүүлэн сайн засаглалтай, эрүүл үйл ажиллагаа эрхлэхийг хичээн ажиллаж байна.

Мөн бид Германы хамийн ажиллагааны нийгэмлэгийн барилгын салбарт мэргэжилтэй ажилтныг үйлдвэр дээр бэлтгэх, сургалтын чанарыг сайжруулах, эрчим хүчний технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэхэд чиглэж буй "Барилгын салбар дахь стратегийн түншлэл" төсөлд хамтран ажиллаж байна.


**МОНГОЛЫН БАРИЛГЫН ҮНДЭСНИЙ АССОЦИАЦИ**  

**giz**  
 Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) GmbH  

**GERMAN-MONGOLIAN INSTITUTE FOR RESOURCES AND TECHNOLOGY**  


**МОНГОЛЫН ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН ХОЛБОО**  


**МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ**  
 MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY  



# Амьдрахад илүү таатай хотууд байгуулахад бид туслана.

1. **Шал**- бүх төрлийн шалны дулаан/дуу чимээ тусгаарлагч чулуун хөвөн хавтан
2. **Дээвэр**- чулуун хөвөн дуу чимээний тусгаарлагч нь өрөөний чимээг хамгийн сайн шингээнэ
3. **Дотор хана**- ямар ч төрлийн материалын хийцтэй барилгад тохиромжтой өрөө хоорондын дуу чимээ, гал тусгаарлагч чулуун хөвөн хавтан
4. **Төмөр бүтэц**- галын аюулын үед гарах өндөр температураас шүршдэг чулуун хөвөн нь хамгаална.
5. **Доргио чичиргээ**- чулуун хөвөн нь барилгад мэдрэгдэх гадны чичиргээнээс хамгаална.
6. **Шинэ технологийн шийдэл**- чулуун хөвөнгийн үүрмэгийг машин техникийн тормозны накланданд ашиглана.
7. **Гадна фасад**- галын өндөр хамгаалалттай, өнгө дизайны өргөн сонголттой дулаан тусгаарлагчтай гадна фасад систем
8. **Хавтгай дээвэр**- үйлдвэрлэлийн болон олон үйлчилгээний барилгуудын дулаан алдагдлыг зогсоох, галын хамгаалалт болон дуу чимээ тусгаарлах зориулалттай чулуун хөвөн хавтан.





Contact us if there  
are any questions.

---

**CORPORATE WEBSITE**

[www.basaltwool.mn](http://www.basaltwool.mn)

---

**PHONE NUMBER**

75114444

---

**EMAIL ADDRESS**

[Monbasalt@rockwool.mn](mailto:Monbasalt@rockwool.mn)